



## МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

**Дугаар:** 2010/05  
**Огноо:** 2010 оны 5-р сарын 10  
**Эмбарго:** 2010 оны 5-р сарын 12-ны Лхагва гаригийн 11:00 цаг хүртэл

Монголбанкны Захирлуудын зөвлөл 2010 оны 5-р сарын 10-нд хуралдаж мөнгөний бодлогыг чангаруулах эсэх асуудлыг авч хэлэлцлээ. Тус хурлаас Монголбанкны бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлж 11.0% болгох шийдвэр гарсан бөгөөд тус шийдвэр 5-р сарын 12-ноос эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Ингэснээр Төв банкны дахин санхүүжилтийн хүүнүүд мөн ялгаагүй 1 нэгж хувиар нэмэгдэх болно. Монголбанк бодлогын хүүгээ өсгөж байгаа нь мөнгөний бодлогоо чангаруулж буйн дохио юм.

Монголбанк тухайн үед мөнгөний захын тогтвортой байдлыг хангахын тулд бодлогын хүүгээ 14.0%-д хүргэж байсан. Харин банкны систем тогтворжихын хэрээр 2009 оны 5 дугаар сараас хойш Монголбанк бодлогын хүүгээ 3 удаа бууруулж 10%-д хүргээд байсан билээ.

Монголбанкнаас 2010 онд ч мөнгөний бодлогоо зөөлрүүлэхээр төлөвлөж байсан боловч харамсалтай нь нөхцөл байдал ийм боломжийг олгохооргүй байна.

Үндэсний Статистикийн хороо 4 дүгээр сарын статистик мэдээгээ гаргаад байна. 2010 оны 4 дүгээр сарын байдлаар инфляцийн түвшин Улаанбаатар хотод оны эхнээс 11.4%-иар, жилийн 8.4%-иар өссөн үзүүлэлттэй байна. Үнийн өсөлт ноднингийн мөн үетэй харьцуулахад ихээхэн хурдацтай байгаа бөгөөд жилийн илэрхийллээр ч тэр, оны эхнээс ч тэр Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлд (ТМБҮЧ) заагдсан 8%-иас нэгэнт даваад байна.

Үнэ ийнхүү хурдацтай өсч байгаа нь хэд хэдэн хүчин зүйлстэй холбоотой. Өнгөрсөн өвлийн зуднаас болж өнөөдрийн байдлаар 7.5 сая мал хорогдсон мэдээ байна. Энэ нь махны нийлүүлэлт, улмаар махны үнэд шууд сөргөөр нөлөөлж байна.

Зөвхөн он гарсаар мах махан бүтээгдэхүүний үнэ 64.2 хувиар өсөв. Улсын нөөцийн мах худалдаалагдаж байгаа боловч махны үнэд дорвитой нөлөөлж чадахгүй байна.

Үүний сацуу цахилгаан, дулаан, ус, суурин утасны ярианы тариф гэсэн төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнэ ноднингийн мөн үеэс 10-37.5%-ийн хооронд өссөн нэмэгдсэн байна.

Үнийн өсөлтийг үндсэндээ нийлүүлэлтийн хүчин зүйлс тодорхойлж байсан тул өнөөдрийг хүртэл Монголбанк мөнгөний бодлогоо шууд чангаруулалгүй, харзсан байр сууринаас хандаж ирсэн билээ.

Хүний хөгжлийн сангаас энэ онд иргэн бүрт 120 мянган төгрөг олгохоор болсон. Үүний 70 мянган төгрөгийг тарааж эхэлсэн 2 болон 4-р сарын инфляци өмнөх сараас илүү өсөлттэй гарсан нь ажиглагдаж байна.

Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэл, Засгийн газрын 3-н талт хэлэлцээрийн үр дүнд төрийн албан хаагчдын цалинг 10-р сарын 1-нээс эхлэн 30%-иар нэмэхээр болсон. Төрийн албан хаагчдын цалингийн өсөлт нь хувийн секторын цалингийн өсөлтийг дагуулдаг бөгөөд энэхүү үйл явц бэлэн мөнгө тараахтай давхцаж байгаа нь инфляцийн хурдцыг нэмэгдүүлэн, инфляцийн хүлээлтийг улам дэвэргэж болзошгүй байна.

Инфляци энэ эрчээр өсөн нэмэгдвэл хүн амын бодит орлого үнэн хэрэгтээ буураад зогсохгүй, төгрөгийн өгөөж багасч мөнгөний захын тогтвортой байдал алдагдах эрсдэлтэй юм.

Иймээс Монголбанк дунд хугацааны үнийн тогтвортой байдлыг хангах, инфляцийн хүлээлтийг бууруулах зайлшгүй шаардлагын үүднээс мөнгөний бодлогоо чангаруулж байна. Цаашид Монголбанкнаас мөнгөний захын болон банкны системийн тогтвортой байдлыг хангахын тулд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллах болно.

## **МОНГОЛБАНК**